



КРЕДИТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ББСБ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 1 сарын 2-ны өдөр

№ 2021/0-01

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй  
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 1 сарын 2-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Экс ХХК-ийн үйл ажиллагаа өргөжин тэлж байгаатай холбогдуулан Ард Кредит ББСБ ХК-ийн Цахим мөнгө гаргах тусгай зөвшөөрлийн хүрээнд Ард Экс ХХК-ийн харилцагчдад үйлчилгээ үзүүлэх Хамтран ажиллах гэрээ байгуулах, Ард Кредит ББСБ ХК-ийн өмчлөлийн хувийн орон сууцны ашиглалтыг Ард Пропертиз ХХК-д хариуцуулах ажил гүйцэтгэх гэрээ байгуулах зөвшөөрлийг олгож, Сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал Г.Тэлмэнд үүрэг болгосугай.
3. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурьдсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод Аудитын Хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ